

МОНГОЛ УТГЫН СУРГААЛЫН ХУРЛЫГ ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ
БӨХХИШИГИЙН НАЙРУУЛАХУЙ-ХЭВЛЭХҮЙ АЖИЛЛАГАА
ХИЙГЭЭД ҮЗЭЛ САНАА

Сэцэн*, Хан Сарнаа**

* Өвөр Монголын их сургуулийн Монгол Судлалын дээд сургуулийн доктор, профессор
** Өвөр Монголын Эмэгтэйчүүдийн хурлын "Эмэгтэйчүүд" сэтгүүлийн найруулагч

Түлхүүр үг: Бөххишиг, Монгол утгын сургаалын хурал, "Улаан барс" сэтгүүл, найруулахуй-хэвлэхүй ажиллагаа, үзэл санаа

1927 оны нэгдүгээр сарын 23-ны өдөр Бөххишиг (1902-1943) нутаг нэгт долоон оюутны хамтаар Монгол утгын сургаалын хурлыг Бээжинд байгуулж "Улаан барс" сэтгүүлийг эрхлэн гаргажээ. Бөххишиг Монгол утгын сургаалын хурлаар дамжуулан үлэмж олон ном сэтгүүл хэвлэн тарааж, сургууль байгуулан хүнийг хүмүүжүүлж, "аливаа сургаал эрдмийг монгол утга дээрээ дэлгэрүүлэх"-ээр насан турш шамдан зүтгэжээ.

Бөххишиг бол сэтгүүлч, найруулагч, хэвлэгч, сурган хүмүүжүүлэгч, ардчилсан үзэлтэн, эдийн засагч, монгол үндэстний соёл, сурган хүмүүжлийн үйлсийн төлөө насаараа зүтгэсэн соёлын зүтгэлтэн болно.

Нэг. Бөххишигийн найруулахуй-хэвлэхүй ажиллагаа

Бөххишиг бол нэрд гарсан монгол үндэстний хэвлэлийн зүтгэлтэн болно.

Түүний эрхэлсэн Монгол утгын сургаалын хурал нь монгол үндэстний орчин үеийн хэвлэлийн байгууламжийн дотор томоохон байр суурийг эзэлдэг. Үүнийг Бөххишигийн хатуужил чармайлт хийгээд гарамгай удирдлагаас салгаж үзэхийн аргагүй юм.

1. Ерөнхий найруулагчийн хэв чанарыг бүрэлдүүлсэн хэрэг мэдэгч

1.1. *Эрдэм шинжилгээний ажлыг гардан хийсэн нь.* Бөххишиг "Монголын нууц товчоо"-г орчин цагийн монгол хэлээр буулгаж, "Эрдэнийн товч"-ийг тулган тайлбарлаж, хэвлүүлэн тараажээ. Ялангуяа түүний буулган тайлбарласан "Монголын нууц товчоо" хожмын үеийн судалгаанд үнэт хэрэглэгдэхүүн болон үлджээ.

1.2. *Найруулагч ба харгуулагчийн ажлыг гардан хийсэн нь.* Бөххишиг "Монгол, хятад аялгууг хосолсон бичиг", "Сен Вангийн дуулал", "Хэлмэрчийн үгс", "Хавт үгс" зэргийг эмхэтгэн цуглуулсан буюу найруулан зохиосон бүтээлээ "Улаан барс" сэтгүүлд нийтлүүлж байжээ. Тэрээр бас "Хөх Монголын хөх туг", "Хөх судар" зэрэг Монгол утгын сургаалын хурлаас

гаргасан арав орчим ном бичгийг хянан тохиолдуулж, залруулан засах найруулагч ба нийлэгчийн ажлыг гардан хийж байв. Бөххишиг найруулахуй-хэвлэхүй ажиллагааны талаарх шалгарсан тухайлсан ажлын хэв суртлаараа үлгэр дуурайл болсноор барахгүй, Монгол утгын сургаалын хурлын хэвлэлийн ажиллагаанд үзүүлбээс зохих хандиваа нэмэрлэжээ. Иймээс Бөххишиг бол нэгэн монгол ном сэтгүүл найруулж хэвлэх ажиллагаанд мэргэшсэн хэвлэгч болно.

1.3. "Улаан барс" сэтгүүлийг эрчимтэй эрхэлсэн нь. "Улаан барс" сэтгүүл дээр эрдэм шинжилгээний ажлыг эрчимтэй хийсэн байна. Бөххишиг эрдэмтдийг чөлөөтэй ярилцуулж, "Улаан барс" сэтгүүл дээр шинэ үг нэр томъёог орчуулан тогтоох ажлыг өрнүүлсэн бөгөөд тус сэтгүүл дээр зан үйлийн судалгааны зохиол бүтээл ба эрүүл хамгааллын судалгааны зохиолыг нийтэлж, эрдэм шинжилгээний зохиолын баримжаагаар "Улаан барс" сэтгүүлийн нийтлэлийн агуулгыг зохион найруулж, уг сэтгүүлийг нийгмийн шинжлэх ухаан ба байгалийн шинжлэх ухаантай холбогдсон баялаг агуулга бүхий ерөнхийлсөн чанартай сэтгүүл болгон эрхэлж чадсан байна.

Бөххишигийн "Улаан барс" сэтгүүлийг эрхэлж байсан хугацаанд уг сэтгүүл сар бүр тогтсон цагтаа хэвлэгдэж байжээ. Сар тутмын сэтгүүл нь энгийн үед тухайн сарын хамгийн сүүлчийн өдөр хэвлэгддэг байжээ. Түүнчлэн Бөххишиг "Улаан барс" сэтгүүлийг голлон эрхэлж байсан хугацаанд "Элдэв зүйлийн нам бүлгэмийн тунхаглан тараах бодлоготой үгс"-ийг зохиол бүтээлдээ оруулж болохгүй гэсэн Хурлын дүрмээ чанга

баримтлан ажиллаж байжээ. "Улаан барс" сэтгүүлийн тавдугаар хугацааг дуустал нийтэд нь ажиглахад ямар нэгэн нам бүлэг, улс төрийн бүлгэмд хэлбийсэн зохиол бүтээл өөр хэвлэгдээгүй байгаа нь үүнийг нотолж байна. Гэвч Бөххишигийг нас барсны дараа "Улаан барс" сэтгүүлийн найруулагчаас тэрхүү хэв дундыг баримтлалсан эрдэм шинжилгээний үзэл хандлагыг баримталж дийлээгүй байдалтай байдаг. "Улаан барс" сэтгүүлийн аравдугаарт Манж хаант улс, Япон улсыг магтан хөөрөгдсөн зохиол бүтээл байн байн үзэгдэх болжээ.

2. Хэвлэлийн хороог удирдан зохион байгуулах ажилд шалгарсан эдийн засагч

Монгол утгын сургаалын хурлыг Бээжинд байгуулснаас хойш хоёр жил бололгүй хурлын гишүүд нь тус хурлын ажлыг дэмжиж чадахаа больсноос Кайлүүд хэвлэлд шилжих хүртэл Монгол утгын сургаалын хурлын бэл мөнгө цуглуулахаас эхлээд хурлын байр эрэх, машин төхөөрөмж бэлтгэх, хурлын гишүүн элсүүлэх зэрэг бүх ажлыг Бөххишиг гагц өөрийн хүчинд түшиглэн явуулж байжээ. Бөххишиг Монгол утгын сургаалын хурлаа биеэ даасан, ардаас эрхэлсэн аж ахуйн маягаар эрхэлж, тус хурлын ажил үйлсээ хэвлэхүй үйлстэй холбогдсон хамаа бүхий ажил төрөл зүг өргөтгөн тэлжээ. Тэрээр Монгол утгын сургаалын хурлаа соёлын ажиллагааны талбар болгож, ном бичиг хэвлэх, сэтгүүл найруулахын хамт сургууль эрхлэх ажлыг хавсаргажээ. Үүнээс Бөххишигт соёл боловсролын ажил үйлс эрхлэх эрч зориг болон бүтээлч чадвар төгс байсныг олж харж болно.

Бөххишиг Монгол утгын сургаалын хурлыг эрхлэн хөтөлж байсан хугацаанд "Улаан барс" сэтгүүл дээр хэвлэлийн хорооны удирдлага зохион байгуулалттай холбогдсон олон арвин мэдээ мэдээлэл нийтлэгдэж байжээ. Жишээлбэл, "Хурлын гишүүдийн доторх дүрэм ёсоор ажил хийсэн мэдүүлэлт ирүүлсэнгүй багш нарын нэрийг илтгэж устгах явдлыг урьдаас мэдэгдэхийн учир"¹, "Шинэ орсон хурлын гишүүний нэр" гэх ажилтны хамааралтын тухай, "Монгол үсгээр өөрснөө зохиосон үлгэрийг шан гаргаж элсэх тухай"², "Аливаа хурлын гишүүд хийгээд бус хүн тус хуралд зохиолт явуулахад доорх хэдэн зүйлийг увайлах хэрэгтэй"³ зэрэг эх бичиг элсэлтийн тухай зар, "Урьдаар үнийг тушаах урт болзооны дүрэм"⁴, "Тус хурлын газраа урагш дармаллан гаргасан хэдэн зүйлийн хуучин бичгүүдийг шинэ бичгүүдээр сольж авахаа мэдэгдэхийн учир"⁵ зэрэг хэвлэгдэхүүний борлуулалтын тухай арга авцал, "Уул хуралд тусалсан халуун сэтгэлт аругай нарын алдар нэрийн илтгэл", "Урдал гардлын илтгэл", "Үүр үндэс болгох мөнгөний илтгэл", "Тангараглах үгс"⁶, "Хөх судар"-ын үнийг өсгөх тухай дагалдуулан мэдэгдэхийн учир"⁷ зэрэг эдийн засгийн хамааралтын тухай зарлал хийгээд олон газарт албан бичиг явуулж нийгмийн харилцаагаа шулуутгаж, зах зээлээ өргөтгөн нээсэн тухай мэдээ мэдээллийг удаа дараагаар нийтлүүлж байжээ. Иймэрхүү дүрэм тогтоол, зар нийтлэлээрээ дамжуулж Монгол утгын сургаалын хурлын ажлаа нэн урагштай болгож чаджээ. Эдгээр нь Бөххишигийн хэвлэлийн хороог удирдан зохион байгуулах чадварыг

гүйцэд эзэмшсэн хэвлэлийн хорооны удирдлагын хэв чанарыг бүрдүүлсэн соёлын эдийн засагч болохыг бүрэн гэрчилжээ. Иймээс Бөххишиг бол соёлын аж үйлсийн шалгарсан эрхлэгч бөгөөд монгол хэвлэхүй үйлсийн удирдлага зохион байгуулалтын ажилд шалгарсан эдийн засагч болно.

Хоёр. Бөххишигийн найруулахуй-хэвлэхүй үзэл санаа

Бөххишигийн нэгэн насны амьдрал тэмцлийн байдлыг шинжилбэл, түүний ядуу буурайчуудыг халамжлан дэмжсэн ардчилсан үзэл, монгол үндэстнийхээ хөгжлийн замыг хайсан үндэстний үзэл ба утга соёлоор угсаа аймгаа тэнхрүүлэх гэсэн сэнхрүүлэх үзэл нь товойм байдаг. Бөххишигийн эдгээр үзэлт танилт нь түүний нэгэн насны чухал ажил үйлс болох найруулахуй-хэвлэхүй ажиллагаанд нь гүн тусгалаа олсон байна.

Бөххишиг хэвлэхүй ажлын тухай нэлээд системчилсэн танилтай байдаг бөгөөд түүний найруулахуй-хэвлэхүйн үзэлт танилт нь түүний Монгол утгын сургаалын хурлын ажлыг эрчимтэй эрхэлж чадсан үзэл санааны удирдамж болно. Бөххишигийн найруулахуй-хэвлэхүйн үзэл санааг сүвэгчлэн тодорхойлж гэмээн сая орчин үеийн монгол үндэстний хэвлэлийн зүтгэлтэн болох Бөххишигийн тухай нэн гүнзгий ойлголттой болж чадах юм.

1. Төрөлх монгол хэлээрээ ном сэтгүүл найруулж хэвлүүлэхийг зорьсон нь

Бөххишиг "Хүн ер өөрийн үг үсгээн хамгаалж, өөрөө тогтнохыг хичээхгүй болбоос, бусдын сайхан будаа, яруу

дууныг итгэвээс, сонсовч баясгаланг төрүүлж үл чадах нь бус болой”⁸ гэж үздэг. Монгол утгын сургаалын хурлын “Хураангуй дүрэм”-д: “Тус хурал болбоос монгол утгаа сүвэгчлэн нягталж аливаа сургаал эрдмийг монгол утга дээрээ дэлгэрүүлэн...” гэж тогтоосон шигээрээ Бөххишиг энэхүү дүрмээ хатуу баримтлан монгол утгын сургаалын хурлаас хэвлэсэн ном сэтгүүлээ монгол үсгээр найруулан зохиохыг хичээж байжээ.

1.1. Монгол үсгийн ном бичиг хэвлэхийг зарчим болгон баримталсан нь. Бөххишиг “Монгол язгуурын түүх”-ийн оршилдоо: “Хүн төрөлхтөн орчлонд аж төрөхүйд эрхбиш тэргүүнд аймаг угсаагаа тусалж тэтгэх ба олон түмэнд завшаан буяныг эдлүүлэхийг гол зорилт болгож, тус тусдаа эрдэм номыг

хүчлэн сурч энэхүү журамт явдлаа бүтээсүгэй хэмээх нь чухамхүү тус зүйтэй мөн буй за. Тийнхүү эрдэм номыг анх сурахуйдаа тус тусын дөхөм дөтийг бодож аль улс аймгийн утгаар судлавч эцэстээ эрдэм номыг сурч төсөөлсний хойно эрхгүй тус аймгийн олон түмэндээ завшаан буяныг эдлүүлэх тухай өөрийн сурсан эрдэм номоо өөрийн утга хэлээр дэлгэрүүлбээс сая түүний сурсан эрдэм номын гавьяа тус нь илэрч уг зорилт нь бүтэж болмуй. Хэрвээ анханд эрдэм номыг бусад аймгийн утгаар сураад эцэст дэлгэрүүлэхүйдээ мөнхүү бусад аймгийн утгыг хэрэглэх аваас харин

өөрийн аймаг угсаандаа өчүүхэн ч ашиг тус болохгүйгээр үл барам нэн өөрийн аймаг угсаагаа бусад аймагт улбаригж устгуулах зовлонд тохиолдуулмуй... Зарим нэгэн манай Монголын эрдэмтэн багш нар олонх нь энэ буруу замд ташааран орсон бөгөөд бас ч ухаарахгүй шууд бусад аймгийн утгыг гол болгож хүндэтгэн, өөрийн аймгийн утгаа хэрэггүй хэмээн хөнгөлөн үзэж гээгдүүлэхүйд хүрчээ. Энэ нь эртнээс эдүгээд хүрч иртэл өөрийн монгол утгаар орчлонд ахуй ... бичиг хар

«
*Бөххишигийн нэгэн насны амьдрал
тэмцлийн байдлыг шинжилбэл,
түүний ядуу буурайчуудыг
халамжлан дэмжсэн ардчилсан
үзэл, монгол үндэстнийхээ
хөгжлийн замыг хайсан
үндэстний үзэл ба утга соёлоор
угсаа аймгаа тэнхрүүлэх гэсэн
сэнхрүүлэх үзэл нь товойм байдаг.*

»

зохиосон эрдэмтэн үгүйн харгайгаар утга үсэг нь гээгдэж угсаа аймаг нь улбарин мөхөх зовлон нүдний өмнө хүрч ирсэн болой... Хүсэх нь өндөр гэгээн эрдэмтэн багш нар доорд хурлын санаа үзлийг зөвшөөрөн айлтгаваас эрхгүй монгол утгаа хүн-

дэтгэж, өөрийнхийгөө хөнгөлж бусдынхыг хүндэтгэх тэр мэт хэлбэлзсэн санаагаа гамнаж, Сагансэцэн хунтайжаар толь болгон түүний мөрийг мөрдөж, монгол утгаар элдэв бичиг харыг зохион бичиж салхины дотор барьсан зул мэт болсон монгол аймгаан тэтгэн тэнхрүүлбээс сая доорд хурлын хэдий чинээ он хүсэн чармайж энэ бичгийг дармаллан гаргасан өчүүхэн бодлогыг хоосдуулахгүй болой”⁹ гэж давшсан үндэстний соёл мэдлэгийг сурч эзэмшсэний дараа заавал өөрийн үндэстний үг хэл, үсэг бичгээрээ зохион найруулж, цаашид үндэстний соёлоо түгээмэлжүүлэх

хэрэгтэй гэж маш дэлгэрэнгүй тайлбарлаж чухалчилжээ. Хэрвээ бусад үндэстний үсэг бичгийг хэрэглэхэд үүрвэл монгол үндэстнээ "бусад аймагт үлбарих үстгуулах зовлонд тохиолдуулмай" гэж сэрэмжлүүлж, үндэстний үсэг бичгээрээ ном бичиг зохион найруулж, хэвлэн тархаахын чухал чанарыг чангатгажээ.

Бөххишигийн монгол үсэг бичгээрээ ном бичиг хэвлэхийг зорьж байсныг түүний "Монголын нууц товчоо"-г "арваад оны хүчийг монголчлон хэвлүүлснээс тод харж болно. "Монголын нууц товчоо" уул нь чухам ямар үсгээр бичигдсэн тухай судлаачдын үзэлт харилцан адилгүй байдаг юм. Гэхдээ бүхний мэдээжээр манай үед уламжлан ирсэн "Монголын нууц товчоо" бол хятад үсгээр монгол үгийг галиглан тэмдэглэсэн эх болно.

«Одоогийн байдлаар "Нууц товчоо"-гийн судалгаа дэлхий нийтээр өрнөж, дотоод гадаадад арван хоёр бүлэгт "Нууц товчоо" болон арван таван бүлэгт "Нууц товчоо" хэдэнтээ хэвлэгдсэнээс гадна хятад хэлний шинэ орчуулга, тайлбар хадсан "Нууц товчоо" зэрэг гарав. Гадаадад Орос, Япон, Англи, Франц, Герман, Унгар, Чехославк, Турк зэрэг улс үндэстний хэлээр орчуулагдан хэвлэгдсэн бөгөөд бас латин галигаар сийрүүлсэн тайлбар хадсан толь хийсэн хэвлэл өдий төдий буй»¹⁰. Үүнд XX зууны 20-30-аад онд монгол үндэстний нандин дурсгалт бичиг "Монголын нууц товчоо"-г "улс бүр цөм түүний хэл дээрээ орчуулан аваад шүүмжилж бүхий"-г хараад Бөххишиг "Манай Монголдоо эдүгээ болтол монголчлон авсан дэвтэр хэмээн үгүй"¹¹ гэдгийг

сэрж олоод, "Монголын нууц товчоо"-г орчин цагийн монгол хэлээр сийрүүлэн буулгав. 1917 онд Дагуурын Цэнд гүн "Монголын нууц товчоо"-г хэвлүүлсэн боловч тэр нь гар бичмэлийн хэлбэрээр үлдэж иржээ. Бөххишигийн "Монголын нууц товчоо"-г хэвлүүлсэн явдал нь орчин үеийн түүхэн дэх "Монголын нууц товчоо"-г эх монгол хэлээрээ сийрүүлэн буулгаж, олон хувиар нийтийн хүртээл болгон хэвлэж дармалаагүй байсан хоосон орон зайг нөхвөрлөжээ.

1.2. Монгол үсгээрээ зохион найруулахыг урамшуулан хөхиүлсэн нь. Бөххишиг "Улаан барс" сэтгүүлийг найруулахдаа ч "өөрийнхөөр үндэс болгох" зарчмыг баримтлан "монгол хүний өөрсдөө зохиосон" түүх судар, газар зүй, зан дадал, ажил амьдрал, шинжлэх ухаан, ерийн мэдлэг, эрүүл мэнд хамгаалал, үлгэрийн зохиол, шүлэг дуу зэргийг "монгол утга дээрээ дэлгэрүүлэх"-ийн төлөө олон хэлбэрийн шагнал ч гаргаж байжээ. Жишээлбэл, "Улаан барс" сэтгүүлийн дөрөвдүгээрт нийтлэгдсэн "Монгол үсгээр өөрснөө зохиосон үлгэрийг шан гаргаж элсэх тухай" гэх мэдээлэлдээ: "Манай монгол угсаатан өөрийн үг бичгээ эрхэлсэнгүйн харгайгаар одоо харин бусдад улбарин шингэгдэх түгшүүртэй болсон нь бус уу, одоох аливаа буй бүхүй бичиг хар бултаар хятадаас орчуулан авснаас бус монгол хүний өөрөө зохиосон бичиг хэмээн өдрийн од адил цөөн болой. Ийм бөгөөд хэрхэн монгол угсаа өөрийн утга соёлоо бадруулан бусдад улбарин шингэгдэх аюулаас зайлуулж чадах ажээ"¹² гэж монгол үсэг бичгээр өөрсдөө зохион бичихийг чухалчилж байжээ.

2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг эрхэмлэн сурталчилсан нь

Бөххишиг ямар ч нам бүлэгт харьяалагдахгүй биеэ даасан хэвлэл мэдээллийн байгууллагыг эрхлэхийг зорьж байжээ. Монгол утгын сургаалын хурлаа эрхлэхдээ эдийн засгийн талаар тухайн Манж гадаад улсын засгийн газрыг түшиглэсэнгүй учраас тус хурал нь зохих эрх чөлөөтэй байж, засгийн газрын "дуу хоолой" болох тавилангаас зайлсхийж чаджээ. Монгол утгын сургаалын хурлын "Хураангуй дүрэм"-ийн арван зургаадугаар зүйлдээ: "Хурлын гишүүний ажил хийсэн мэдүүлэлт дотроо элдэв зүйлийн нам бүлгийн тунхаглан тархах бодлоготой үгс"-ийг оруулж болохгүй гэж тов тодорхой тогтоосон байдаг.

Бөххишиг дүрэм тогтоолдоо уриа лоозон төдий хий хоосон хашгирсан бус, харин ч энэхүү дүрэм тогтоолоо чанга журамлан хэрэгжүүлсэн байна. Тухайн үед Хянган баруун мужийн утга суртахууны салаан дарга байсан Бөххишиг Манж улсад тушаал үүрэглэж байсан боловч Бөххишигийн үйл ажиллагаанд Японы колоничлолыг өргөн магтсан буюу Манжийн ноёрхлыг магтан хөөрөгдсөн зүйл огтхон ч харагдахгүй юм. "Улаан барс" сэтгүүлийн нийтлэлийн агуулгыг ажиглавал Бөххишигийн "Улаан барс" сэтгүүлийг эрхэлж байсан хугацаанд уг сэтгүүлд Япон Манжийн тухай мэдээлэл тун цөөн нийтлэгдэж, нэн ялангуяа Японы түрэмгийлэлд үйлчилсэн боолчлолын буюу тэдний ухуулга сурталчилгааны зохиол бүтээл нийтлэгдээгүй байна. "Улаан барс" сэтгүүлийн дөрөвдүгээрт нийтлэгдсэн "Манж улсын дуулал", тавдугаарын дөрөвдүгээр тэмдэгт нийтлэгдсэн "Манж улсын аймаг угсаа"

зэрэг нь зөвхөн Манж улсын дуу хийгээд үндэстний бүрэлдлийн тухай дөхөм танилцуулга хийсэн зохиол бүтээл төдий болохоос харин түүнийг магтаж сурталчилсан хэлбэрэл огт биш юм.

Монгол засгийн журганы зөвшөөрлийн бичигт: "...үйлдэн хийсэн бүтэмжтэй зүйлээ цагчлан өргөн батлахаар ирүүлж, уул журганы зохион хянахаар бэлтгэтүгэй"¹³ гэж байсан мөртөө цагдаагийн явдлын газраас дармаллах гэж байгаа хэвлэгдэхүүнийг хянан байцаах зөвшөөрлийн бичиг олгож байжээ. Манж улсын засгийн газраас Монгол утгын сургаалын хурлын хэвлэсэн ном сэтгүүлийг хянан байцааж, монгол үндэстний хэвлэхүй үйлст тусгай хорио цааз тогтоож хэвлэлийн эрх чөлөөг нь хүлээслэж байжээ. Монгол утгын сургаалын хурлаас "Улаан барс" сэтгүүлийг хэвлэн тараахад амрыг хамгаалах хэлтсээс хэвлэгдэхүүнийг тараахыг зөвшөөрсөн гэрч бичиг олгож байсан мөртлөө ном бичиг хэвлэн дармалласны дараа Кайлүү сяаны цагдаагийн салаанаас хянан байцааж, зөвшөөрлийн бичиг олгож байжээ. Гэвч Бөххишиг эдгээрийг хайхралгүй Монгол утгын сургаалын хурлаараа дамжуулан монгол үндэстнээ соёлоор хөгжүүлэхэд түүний үзэхээр хийвээс зохих ажил үйлсээ шалавлан хийжээ.

Бөххишиг "Улаан барс" сэтгүүл дээрээ Япон, Манжийн засгийн газрын тухай ямар ч улс төрийн хэлбэлзэлтэй зүйлийг мэдээлдэггүй боловч монгол үндэстнийг тэтгэн тэнхрүүлэх зохиол бүтээлүүдийг аль олон нийтэлдэг байжээ. Энэ нь япончуудын уг санаа зорилтын яг эсрэг чиглэсэн учраас Бөххишигийн Монгол

утын сургаалын хурлын ажилд олон хууль саад тохиолдуулж байжээ. Тухайлбал, "Улаан барс" сэтгүүлийн "Улаан" гэдэг үгээс шалтаг эрж Бөххишигийг байцааж байсан удаа ч байдаг. Арга мухардсан япончууд Бөххишигийг өргөн дэвшүүлэх нэрээр соёл, сурган хүмүүжлийн фронтоос нь салгажээ. Бөххишигийн садан Төвшинбаярын эргэцүүлснээр тухайн жилүүдээр Бөххишиг үргэлж "Энэ муу ертөнц өө! Илжигтэй ламыг чинь нохой зуулаа шүү!"¹⁴ гэж эрх чөлөөгөө алдсан голч бус ахуй байдалд хорсон гашуудаж байжээ.

3. Сонгодог бүтээлийг хэвлэх соёлын ухамсартай байсан нь

Хэвлэгдэхүүний сэдэв сонголтын талаар Бөххишиг монгол үндэстний сонгодог бүтээлүүдийг хэвлэн дармаллахын чухалчилж, нөр их хөдөлмөр зарцуулж, эртний сонгодог бүтээлүүдийг сонгож сийрүүлэн бичих, сийрүүлэн буулгах ба эмхэтгэн цуглуулах ажлыг биеэр хийжээ.

Бөххишиг "Хубилай сэцэн хааны үед монгол бичгийг тулгар зохиолгосон боловч хойчийн хүмүүс нь дэмий бурханы номыг үлэмж орчуулан дэлгэрүүлж талаар орхисноос бус эдүгээд хүрч иртэл Монголын түүх судар, бичиг харыг монгол үсгээр зохиогоод ертөнцөд нэр алдаршуулсан нь гагцхүү энэ нэгэн зүйлийн бичгээс гадна өөр нэгээхэн ч үгүй"¹⁵ гэж "Монгол язгуурын түүх"-ийг хэвлэхийн чухал чанарыг танин ухаарч, 1932 оноос эхлэн гурван жилийн хугацааг зарцуулан сийрүүлэн бичиж, эрдэмтэн багшаар хянуулан засуулж хэвлэн тараажээ. Бөххишигийн "Монгол язгуурын түүх"-ийг хэвлэсэн гол зорилт нь маш тодорхой байж, "юуны урьд дармаллан гаргаж

үзэл санаа нь бусад аймгийн утга соёлд нэрвэгдсэн энэ цагийн дүү нарыг сэнхрэн ухтугай хэмээх чин үнэн санаа болой"¹⁶ гэж "Монгол язгуурын түүх"-ийг хэвлэсэн гол зорилт бол бусад үндэстний бичиг соёлд тархиа угаалгасан монгол залуусыг дуудан сэргээхийн төлөө гэдгээ тодорхойлж байв. Энэ оршлоос бид Бөххишигийн хэвлэгдэхүүнийхээ нийгмийн үр ашгийг эцнээ давхарга хүртэл гүйцэд бодолхийлж байсныг мэдэж болно.

Үүнээс гадна Бөххишиг урьд хожид арван жилийн хугацаагаар "Монголын нууц товчоо"-г монгол хэлээр буулгаж, хэвлүүлэн тараажээ. Мөн Инжанна-шийн "Хөх судар", "Жи хун тин", "Нэгэн давхар асар" зэрэг зохиол бүтээлийг хэвлүүлэхийн төлөө Инжаннашийн нутагт тусгай бичээч Шилингааг томилон эмхэтгэн цуглуулжээ.

"Их Юань улсын мандсан төрийн "Хөх судар" хэмээх энэ бичиг болбоос Баруун Түмэдийн Инжиннаши багшийн зохиосон нь мөн үзэх мэргэд гагц түүний бичсэн оршил ба товчит тольтыг олж үзсэн бүхэн эс биширсэн хүн нэг ч үгүй үнэхээр Монголын богд эрдэмтний зохиолт хэмээж бололтой. Хараахан харьяат бичиг нь хаа ч гэсэн бүрэн бүтэн олдохгүй тул уул хурлаас арав гаруй жилийн хүчийг сүйтгэж зүйл зүйлийн аргаар бараг дотоод монгол хошуудаас эс сурвалжлан асуусангүй газар үгүй, сая арайхан далаад бүлэг олж бас ч бүрэн болгож чадаагүй үүнээс өөр нэмж олсугай хэмээн мөн тасралтгүй чармайж амуй"¹⁷ гэж "Хөх судар"-ын уг эхийг бүрдүүлэхийн төлөө хэр зэргийн цаг хугацаа, хүний хүч зарцуулсан тухайгаа "Улаан барс" сэтгүүлийн дөрөвдүгээрт тэмдэглэсэн байна.

Бөххишиг эдгээр номуудыг хэвлүүлэхдээ номыг түргэн хэвлэж, эдийн засгийн үр ашиг олохыг бодолхийлсэн бус, харин эрдэм шинжилгээний ажлын баримжаагаар номыг нягт, чанарлаг хэвлүүлэхийг эрхэмлэсэн байна.

4. Өртөгт шинжтэй ба сонирхолт шинжтэй зохион найруулахыг баримталсан нь

Ном сэтгүүлийг найруулахдаа үнэ өртөгтэй, сонирхолт шинжтэй байхыг батлах бол Бөххишигийн чухал нэг найруулахуй үзэл санаа болно. Түүний үзэхээр өнгөрсөн үед манай монголчууд "төмөр бурханы номыг үлэмж орчуулан дэлгэрүүлж талаар орхисон"¹⁸ бөгөөд "монгол утгаар өөрийн ухаанаараа ардын мэдлэг, ан занд тустай чухал бичиг судар зохиохыг хичээсэнгүй"¹⁹, бас "утга ёсноо үл нийлэлцэх мэт өөрийн дураас шүлэг ч бус дуулал ч бус юмыг хуудмаар зохиож"²⁰ гэж ямар ч утга агуулгагүй зүйлийг хэвлэн нийтэлж байсан өнгөрсөн үеийн хэвлэгдэхүүний гэм дутагдлыг заан гаргаж, санаа ахуйгаар гүн, утга сэдвээр гүнзгий ач холбогдолтой өртөгт шинжтэй ном зохиолыг зохион туурвиж, хэвлэн нийтлэхийг зорьжээ. Бөххишиг бас "хошин наадам ба инээдэм үгс, шүлэг, магтуу, дуу хөгжим хийгээд бага сага үлгэр түүхийн зэрэг хүнийг бахад оруулах"²¹-ыг бодолхийлж, ном сэтгүүлийг сонирхолтой шинжтэй зохион найруулахыг чухалчилжээ.

Дүгнэж хэлбэл, хэвлэлийн хорооны бүх талын ажилд гавшгайрсан Бөххишиг монгол соёлодоо хайртай, монгол үндэстнээ соёл боловсролоор тэтгэн хөгжүүлэхээр зорьж явсан үлэмж олон дэвшилт сэхээтнийг дайчлан Монгол утгын

сургаалын хурлын ажилтны эгнээг өргөтгөж, монгол хэлээрээ ном сэтгүүл найруулж хэвлүүлэхийг зорьж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, сонгодог бүтээлийг хэвлүүлэх соёлын ухамсартай байсан бөгөөд өртөгт шинжтэй, сонирхолт шинжтэйгээр өөрсдөө зохион найруулахыг баримталж Монгол утгын сургаалын хурлын найруулахуй-хэвлэхүй ажлаа эрчимтэй эрхэлж байжээ.

Ишлэл

¹ "Улаан барс" сэтгүүлийн дөрөвдүгээр тэмдэг.

² Мөн тэнд.

³ "Улаан барс" сэтгүүлийн тавдугаар хугацааны хоёрдугаар тэмдэг.

⁴ Мөн тэнд.

⁵ "Улаан барс" сэтгүүлийн тавдугаар хугацааны зургаадугаар тэмдэг.

⁶ "Улаан барс" сэтгүүлийн тавдугаар хугацааны нэгдүгээр тэмдэг.

⁷ *Эрдэмт, Буянтогтох*. 1992. Бөххишиг хийгээд түүний Монгол утгын сургаалын хурал // Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо, 282 дахь тал.

⁸ Мөн тэнд, 154 дэх тал.

⁹ Мөн тэнд, 235-236 дахь тал.

¹⁰ 2007. Монголын нууц товчоо // Тайчууд Мансан шинээр орчуулж тайлбарлав. Өвөр Монголын Шинжлэх ухаан, техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2-3 дахь тал.

¹¹ 1941. Монголын нууц тууж // Бөххишиг монголчлов. Монгол утгын сургаалын хурал, 1 дэх тал.

¹² "Улаан барс" сэтгүүлийн дөрөвдүгээр тэмдэг.

¹³ Мөн тэнд.

¹⁴ *Эрдэмт, Буянтогтох*. 1992. Бөххишиг хийгээд түүний Монгол утгын сургаалын хурал // Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо, 94 дэх тал.

¹⁵ Мөн тэнд, 232 дахь тал.

¹⁶ Мөн тэнд, 235 дахь тал.

¹⁷ "Улаан барс" сэтгүүлийн дөрөвдүгээр тэмдэг.

¹⁸ *Эрдэмт, Буянтогтох*. 1992. Бөххишиг хийгээд түүний Монгол утгын сургаа-

1. 1992. Монголын нууц товчоо // Тайчууд Мансан шинээр орчуулж тайлбарлав. Өвөр Монголын Шинжлэх ухаан, техник мэргэжлийн хэвлэлийн хороо.
2. 1941. Монголын нууц тууж // Бөххишиг монголчлов. Монгол утгын сургаалын хурал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. "Улаан барс" сэтгүүлийн дөрөвдүгээр тэмдэг.
2. "Улаан барс" сэтгүүлийн тавдугаар хугацааны хоёрдугаар тэмдэг.
3. "Улаан барс" сэтгүүлийн тавдугаар хугацааны зургаадугаар тэмдэг.
4. "Улаан барс" сэтгүүлийн тавдугаар хугацааны нэгдүгээр тэмдэг.
5. Эрдэмт, Буянтогтох. 1992. Бөххишиг хийгээд түүний Монгол утгын сургаалын хурал // Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо.

Резюме

Статья посвящена редакторской и издательской деятельности Буххишига (1902-1943) — известного просветителя из Внутренней Монголии. Авторы, опираясь на первоисточники, предприняли попытку осмысления и анализа его многогранной деятельности, включая издание и распространение книг и журналов на монгольском языке, целенаправленную борьбу за свободу слова и печати, ознакомление читателей с произведениями классиков мировой литературы и т. д.